



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/12

Бор-Өндөр сум

Төгсөх ангийн тайлант өдөрлөг
зохион байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, Хэнтий аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 253 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Сургуулийн төгсөх ангийн сурагчдын тайлант өдөрлөгийн үйл ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр бага боловсрол эзэмшиж, мэдсэн, сурсан авьяасаа тайлагнах хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Тайлант өдөрлөгийн үеэр сурагчийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн санаачилга нэрээр бэлэн мөнгө татах, багшид бэлэг, хандив өгөх, архидан согтуурах, амралт зугаалга зэрэг эцэг эхэд санхүүгийн дарамт учруулах үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосугай.

3.Энэхүү тушаалыг дагаж биелүүлээгүй, зөрчсөн багш, ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ тооцуулахаар холбогдох албан тушаалтанд уламжлахыг нийгмийн ажилтан (Э.Нарантуяа)-д даалгасугай.

4.Дээрх үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сургалтын менежер (М.Нармандах), дотоод хяналтын ахлагч (Л.Ганганмөрөн), нийгмийн ажилтан (Э.Нарантуяа), анги удирдсан багш нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ